



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/473

Арвайхээр

“Хяналт-шийдвэрлэлт 2020” нэгдсэн арга  
хэмжээ зохион явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.л, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.2, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвлийн улирал эхэлж иргэд, малчид хүнс, мод түлээгээ нөөцлөх мал, мах, модны нийлүүлэлтийг дагаад мал хулгайлах, хууль бусаар мод бэлтгэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах, хот хоорондын болон орон нутгийн замд техникийн бүрэн бүтэн байдлыг хангаагүй, зөвшөөрөлгүй тээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэх явдлыг зогсоох, эдгээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх зорилгоор “Хяналт шийдвэрлэлт-2020” нэгдсэн арга хэмжээг 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 45 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.


2.Нэгдсэн арга хэмжээг зохион явуулахад шаардагдах зардлын тооцоог нэгдүгээр, зохион явуулах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.“Хяналт шийдвэрлэлт-2020” нэгдсэн арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй зохион явуулж дүнг танилцуулахыг аймгийн Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа О.Ганбат), Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Д.Одонбаяр), Мэргэжлийн хяналтын газрын дарга (С.Дуламсүрэн), Татварын хэлтсийн дарга (Н.Эрдэнэсүвд), Мал эмнэлгийн газрын дарга (А.Нямдаваа), Авто тээврийн төвийн дарга (З.Балданням) Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Т.Ариунболд) нарт тус тус даалгасугай.

4.“Хяналт шийдвэрлэлт-2020” нэгдсэн арга хэмжээний хүрээнд постонд ажиллах алба хаагч нарт шаардлагатай орон байр, түлээ нүүрс, шатах тослох материалаар дэмжлэг үзүүлэн ажиллахыг Тарагт, Нарийнтээл, Бат-Өлзий, Хархорин, Бүрд, Хужирт, Зүүнбаян-Улаан, Арвайхээр сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5.Нэгдсэн арга хэмжээнд зарцуулагдах 6,000,000 (зургаан сая) төгрөгийг аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (А.Отгонцэцэг)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011101047



Аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 4 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



**“ХЯНАЛТ-ШИЙДВЭРЛЭЛТ 2020” НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД АЖИЛЛАХ ХЯНАЛТЫН ПОСТ, ХӨДӨЛГӨӨНТ ЭРГҮҮЛД ЗАРЦУУЛАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Д/д	Хяналтын пост	Аймгийн төвөөс хэдэн км	Ажиллах хоног	Ажиллах хүн хүч	Шатахууны зардал					Хоолны зардал			Халаалт, цахилгааны зардал /мод, нүүрс/		
					1 ээлж ажиллах хугацаа	Шатахууны хэмжээ	Шатахууны үнэ	Ээлж хүлээлцэхэд зарцуулах шатахууны үнэ	Дүн /мян.төг/	Ажиллах хоног	Хоолны үнэ	Дүн /мян.төг/	Ажиллах хоног	Нүүрс, мод /өдөрт/	Дүн /мян.төг/
1.	Онгийн голын пост	15	40	2	3 хоног	5	1,500	7,500	105,000	40	7,500	200,000	40	13,250	530,000
2.	Тарагт сум баруун гуанзны пост	10	40	2	3 хоног	15	1,500	22,500	292,500	40	7,500	200,000			
3.	Нарийнтээл сумын пост	130	40	2	3 хоног	10	1,500	15,000	195,000	40	7,500	200,000			
4.	Бат-Өлзий сум Үүртийн тохойн пост	110	40	2	3 хоног	10	1,500	15,000	195,000	40	7,500	200,000			
5.	Хархорин сумын уулзварын пост	125	40	2	3 хоног	10	1,500	15,000	195,000	40	7,500	200,000			
6.	Бүрд сум Тарнын пост	130	40	2	3 хоног	25	1,500	37,500	487,500	40	7,500	200,000			
7.	Арвайхээр, Хархорин, Хужирт, Зүүнбаян-Улаан сумд								2.400.000			400.000			
	<b>ДҮН</b>								<b>3.870.000</b>	<b>1.600.000</b>					
									<b>6.000.000</b>						

10 Аймгийн Засаг даргын 2020 оны  
... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

**“ХЯНАЛТ ШАЛГАЛТ 2020” НЭГДСЭН  
АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН ЯВУУЛАХ УДИРДАМЖ**

2020.10.15

АРВАЙХЭЭР

**Нэгдсэн арга хэмжээ байгуулах үндэслэл:**

“Аюулгүй иргэн-Амар тайван Өвөрхангай” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, аймгийн хэмжээнд гарч байгаа мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авто замын тухай хууль, Байгаль хамгаалах тухай хууль, Татварын тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль бусад хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

**Нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах хугацаа:** 2020 оны 10 дугаар сарын 15-наас 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл.

**Нэгдсэн арга хэмжээний хамрах хүрээ, хүн, хүч:**

Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар, Татварын хэлтэс, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Онцгой байдлын газар, Мал эмнэлгийн газар, Авто тээврийн үндэсний төвийн Өвөрхангай аймаг дахь салбар, сумдын Засаг даргын Тамгын газрын алба хаагч нар хамрагдана.

**Удирдлага зохион байгуулалт:**

Нэгдсэн арга хэмжээг Цагдаагийн газар удирдан зохион байгуулна.

Арга хэмжээний хүрээнд түр хугацаагаар байгуулагдсан хяналтын постуудыг байгууллагын дарга нар хариуцан үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллана.

Байгууллагаас ажиллах алба хаагч нарын хуваарийг 7 хоногоор гаргаж, аймгийн Цагдаагийн газарт ирүүлнэ.

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд хариуцсан постын хийж гүйцэтгэж байгаа ажил, ажиллах нөхцөл байдлыг үнэлж дүгнэж, нөхцөл байдалдаа уялдуулан зөрчил, гэмт хэрэг, байгалийн хүндрэл бэрхшээлээс хамаарч хяналтын постыг нүүлгэн шилжүүлэх ажлыг Цагдаагийн газрын даргатай зөвшилцөж өөр газарт шилжүүлэн байршуулж болно.

Арга хэмжээнд Засаг дарга нар сумын алба хаагчийг удирдлага зохион байгуулалт болон шаардлагатай пост байгуулах зөөврийн чингэлэг, гэр, тээврийн хэрэгсэл, хүнс, шатах тослох материалаар хангахад туслалцаа үзүүлнэ.

Хоногийн хугацаанд үүрэг гүйцэтгэх 1 алба хаагчийн хоолны зардал 5000 төгрөгөөр бодогдоно.



Дамжин өнгөрч байгаа мал, малын гаралтай түүхий эдийн Мал эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавьж зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох албан тушаалтан хариуцлага тооцож ажиллана.

Постонд гарах алба хаагчийг 7 хоногоор үүрэг гүйцэтгүүлж нэгдсэн журмаар ээлж хүлээлцүүлж ажиллана.

**Нэгдсэн арга хэмжээг үнэлж дүгнэх:**

Хяналтын пост өдөр тутам мэдээний хүснэгтээр аймгийн Цагдаагийн газрын шуурхай удирдлагын жижүүрийн хоногийн мэдээнд ирүүлж ажиллана.

Пост удирдан ажиллаж байгаа байгууллагын дарга 7 хоног тутам Цагдаагийн газарт танилцуулга ирүүлж түүнийг 14 хоног бүр нэгтгэн аймгийн Засаг даргад хийж гүйцэтгэсэн ажлын танилцуулгыг хүргүүлнэ.

-оОо-